



Монгол Улс: ОУВС-ийн Дүрмийн IV заалтын 2026 оны зөвлөлдөх хэлэлцүүлгийг дүгнэж Ажлын хэсгээс гаргасан мэдэгдэл

ШУУД НИЙТЛЭХ

Энэхүү мэдэгдэлд ОУВС-ийн ажлын хэсгийн ихэнх тохиолдолд гишүүн оронд хийсэн албан ёсны айлчлалын төгсгөлд гаргасан урьдчилсан дүгнэлтийг танилцуулдаг. ОУВС-ийн ажлын хэсэг **Дүрмийн IV** заалтад заасан (ихэвчлэн жил бүр хийгддэг) зөвлөлдөх уулзалтын хүрээнд, мөн ОУВС-ийн санхүүжилтийг ашиглах (ОУВС-гаас зээл авах) хүсэлтийг судлах, ОУВС-ийн мэргэжилтнүүдийн хяналт дор хэрэгжиж буй хөтөлбөрийн яриа хэлэлцээ явуулах, эсвэл эдийн засагт гарсан өөрчлөлтүүдэд шинжилгээ хийх зорилгоор гишүүн оронд очиж ажилладаг. Эрх баригчид энэхүү мэдэгдлийг хэвлэн нийтлэх зөвшөөрлийг олгосон болно. Энэ мэдэгдэлд илэрхийлсэн байр суурь нь ОУВС-ийн ажлын хэсгийн байр суурь бөгөөд ОУВС-ийн Захирлуудын зөвлөлийн байр суурийг илэрхийлэхгүй болно. Энэхүү айлчлалын урьдчилсан дүгнэлтэд үндэслэн ажлын хэсэг тайлан боловсруулж, ОУВС-ийн удирдлагад танилцуулан зөвшөөрөл авсны дараа ОУВС-ийн Захирлуудын зөвлөл хэлэлцэж, шийдвэр гаргана.

Вашингтон хот, 2026 оны 6-р сарын 26: Ноён Тахсин Саади Седикийн ахалсан Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн ажлын хэсэг Дүрмийн IV заалтын 2026 оны зөвлөлдөх хэлэлцүүлгийн хүрээнд Монгол Улсын төрийн эрх бүхий байгууллага, төлөөлөлтэй 2026 оны 6-р сарын 10-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо яриа хэлэлцээ хийлээ. Айлчлалын төгсгөлд ажлын хэсэг дараах мэдэгдлийг гаргав. Үүнд:

- 2025 онд хөдөө аж ахуйн салбар сэргэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл эрчимтэй өссөний үр дүнд эдийн засгийн өсөлт өндөр түвшинд хадгалагдав. 2026 оны эхэн үед уул уурхайн салбарын үйлдвэрлэл энэхүү өсөлтийг үргэлжлүүлэн тэтгэсэн боловч уул уурхайн бус салбарын өсөлт сул байлаа. Хүнс, шатахууны үнэ огцом өсөж, 2025 оны 11-р сараас хойш буурч байсан инфляц сүүлийн гурван сар дараалан нэмэгдэв. Уул уурхайн салбарын төлөв таатай байгаа хэдий ч эдийн засгийн эмзэг байдал өндөр хэвээр байна.
- Төсвийн сахилга батыг хадгалах нь нэн чухал байна. Гол зорилтууд нь өмнө нь тохирсон цалингийн нэмэгдлийг тусгасан төсвийн тодотголыг батлах, уул уурхайн бус татварыг бууруулахаас, мөн урсгал зардлыг нэмж өсгөхөөс зайлсхийхэд чиглэх ёстой. Шинэчлэлүүд нь төсвийн тусгай шаардлагуудыг дагаж мөрдөхийн зэрэгцээ уул уурхайн бус орлогыг нэмэгдүүлэх, зарлагыг оновчтой болгох, төсвийн бодлогын орон зайг сэргээхэд төвлөрөх шаардлагатай байна.
- Одоо ажиглагдаж байгаа хүнс, шатахууны үнийн шок нь инфляцын хүлээлтийг тогтворгүй болгож, хоёр дахь үеийн нөлөө үүсэх эрсдэлийг нэмэгдүүлбэл Монголбанк мөнгөний бодлогоо хатууруулахад бэлэн байх нь зүйтэй. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт нь Монголбанкны бодлого, үйл ажиллагааны үр нөлөөг бэхжүүлэхэд нэн чухал байх болно. Валютын ханшийн уян хатан байдлыг нэмэгдүүлж, гадаад валютын нөөцийг нэмж хуримтлуулах нь гадаад шокийн эрсдэл даах чадварыг бэхжүүлнэ. Макро зохистой бодлогын тогтолцоог нэмж бэхжүүлэх шаардлагатай.

ЭДИЙН ЗАСАГТ СҮҮЛИЙН ҮЕД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД, ЦААШДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЭРСДЭЛҮҮД

Монгол Улсын эдийн засаг хэд хэдэн шокийг үл харгалзан тэсвэртэй хэвээр байна. 2025 онд нүүрсний үнэ огцом буурсан хэдий ч хөдөө аж ахуйн салбар эрчимтэй сэргэж, уул уурхайн салбар, ялангуяа зэсийн олборлолт эрчтэй нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. 2026 он гарсаар уул уурхайн салбарын үйлдвэрлэл эрчимтэй өссөн нь экспорт, эдийн засгийн өсөлтийг мөн дэмжсэн. Хатууруулах бодлогын нөлөөгөөр 2026 оны тавдугаар сард зээлийн өсөлт 17 орчим хувь болж саарлаа. Хүнс, шатахууны үнэ өссөнөөр инфляц нэмэгдэж, тавдугаар сард 11.2 хувьд хүрлээ. Валютын ханш 2025 оны дөрөвдүгээр сараас хойш ерөнхийдөө тогтвортой байсан бөгөөд гадаад валютын улсын нөөц зургаадугаар сарын эхээр 7.4 тэрбум ам.долларт хүрсэн хэдий ч ОУВС-ийн Нөөцийн хүрэлцээний үнэлгээний шалгуураас доогуур хэвээр байна. Зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагууд Монгол Улсын Засгийн газрын зээлжих зэрэглэлийг ахиулж, бондын өгөөжийн нэмэгдэл хүү буюу спрэд буурсан байна.

2025 онд нүүрсний үнэ буурсан нь төсөвт дарамт учруулсан. 2025 онд уул уурхайн орлого буурсны хариуд эрх баригчид төсвийн зарлага санхүүжилтийг чангатгаж, татварын урьдчилгаа төлбөр авах, татварын өр төлбөрийг барагдуулах, зарим зардлын төлбөрийг хойшлуулах, мөн Төсвийн тогтворжуулалтын сангийн эх үүсвэрийг зарцуулах зэрэг арга хэмжээ авсан. Цалинг ихээхэн нэмсэн шийдвэртэй хавсран авч хэрэгжүүлсэн эдгээр арга хэмжээний зарим нь 2026 оны эхээр төсөв дээр үргэлжлүүлэн дарамт болсон боловч тавдугаар сар гэхэд уул уурхайн орлого нэмэгдсэнээр уг дарамт тодорхой хэмжээгээр саарсан.

Шатахууны үнийн өсөлт болон дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал нь сөрөг нөлөө үзүүлж байгаа хэдий ч 2026 онд эдийн засгийн өсөлт харьцангуй өндөр үзүүлэлттэй хэвээр байх төлөвтэй байна. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдэх учраас уул уурхайн бус салбарын сул өсөлтийг тодорхой хэмжээгээр нөхөж, урсгал дансны алдагдлыг багасгахад дэмжлэг болсны үр дүнд ДНБ-ийн өсөлт 5.8 хувьд хүрэх тооцоо гарч байна. Харин хүнс, шатахууны үнэ өндөр хэвээр байгаатай холбоотойгоор инфляц 10 хувь орчимд хадгалагдах төлөвтэй байна.

2026 онд төсвийн тэнцэл доройтох төлөвтэй байна. Энэ нь цалингийн өсөлт, мөн төсвийн тусгай шаардлагын хамрах хүрээнээс хасагдсан хоёр мега төслийн санхүүжилт эхний жилүүдэд төвлөрч, хэрэгжилт нь хурдассантай голчлон холбоотой байна. ОУВС-ийн ажлын хэсгийн суурь төсөөлөлд Засгийн газрын эрсдэл ба өрийн тогтвортой байдлын үнэлгээгээр Монгол Улсын Засгийн газрын эрсдэл 2025 оны тооцоололтой адил буюу дунд түвшинд байна.

Эдийн засаг эмзэг хэвээр байгаа бөгөөд эрсдэлүүд сөрөг тал руугаа давамгайлсан байна. Уул уурхайн бус татварыг нэмж бууруулах, урсгал зардлыг, ялангуяа төрийн албаны бусад салбарын цалин болон тэтгэврийг өсгөх шаардлагын улмаас нэмэгдүүлэх, мөн төсвийн нөөц эх үүсвэрийг ашиглах улс төрийн дарамт нь гол сөрөг эрсдэл болж байна. Гадаад орчны эрсдэлд Ойрх Дорнодын мөргөлдөөний дам нөлөө болон ОХУ, Украины дайнаас үүдэлтэй геополитикийн хурцадмал байдал нэмэгдэх, түүнчлэн БНХАУ-ын нүүрсний эрэлт болон түүхий эдийн үнийн төлөвтэй холбоотой тодорхой бус байдал багтаж байна.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ БОДЛОГО

Өндөр өртөгтэй бодлогын шинэ санал, санаачилгууд гарч буй энэ үед төсвийн тогтвортой байдлыг хангаж, эдийн засаг дахь эмзэг байдлыг бууруулах нь бодлогын нэн тэргүүний зорилт болж байна.

Төсвийн тодотголыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь нэн чухал байна.

Төсвийн тодотголд багш, эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалингийн нэмэгдэл, түүний төсөвт үзүүлэх нөлөөг бүрэн тусгаж, хүлээгдэж буй алдагдлыг санхүүжүүлэхэд шаардлагатай өрийн дээд хязгаарыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Энэ нь 2025 оныхтой ижил бэлэн мөнгөний хомсдол үүсэж, уламжлалт бус, нэг удаагийн орлогын арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл байдал давтагдахаас сэргийлэх зорилготой юм.

Засгийн газар уул уурхайн бус татварыг бууруулах саналаа дахин нягтлах нь зүйтэй. НӨАТ-ын буцаан олголтыг 2 хувиас 5 хувь болгон нэмэгдүүлэх шийдвэрээ буцаасан нь сайшаалтай. Гэхдээ татвар бууруулахаас илүүтэйгээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг оновчтой болгох, татварын өр төлбөрийг барагдуулах, татвар, гаалийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход анхаарах хэрэгтэй. Мөн түүнчлэн нийгмийн хамгааллын зардлыг оновчтой болгож, зорилтот бүлэгт илүү чиглүүлэх шинэчлэлийг хамт хэрэгжүүлэх нь зүйтэй. Ингэснээр түүхий эдийн үнийн шокод өртөх төсвийн эмзэг байдлыг бууруулж, нэн шаардлагатай байгаа хөгжилд чиглэсэн зардал болон төрийн суурь үйлчилгээний санхүүжилтийн орон зайг бий болгох, төсвийн тусгай шаардлагуудыг мөрдөхөд дэмжлэг үзүүлэх, мөн төсвийн нөөц орон зайг дахин бүрдүүлэхэд тусална. Шатахууны үнийн өсөлтийн эсрэг авсан төсвийн хариу арга хэмжээ нь түр хугацаанд хэрэгжих, зорилтот бүлэгт чиглэсэн бөгөөд үнийн дохиоллыг хадгалах шаардлагатай.

Тэтгэврийн шинэчлэл төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх ёсгүй.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн тэтгэврийн шинэчлэлийн багц хуульд параметрийн тохируулга зэрэг эерэг зүйлүүд багтаж байгаа боловч зарим өөрчлөлт нь төсөвт ихээхэн дарамт үүсгэхээр байна. Тухайлбал, эдгээр арга хэмжээтэй холбоотойгоор төсвөөс жил бүр нэмж гарах зардал ДНБ-ийн 1.3 хувь орчимд хүрэх тооцоолол байна.

Төрийн санхүүгийн удирдлага болон төсвийн ил тод байдлыг бэхжүүлэх нь нэн чухал байна. Хоёр мега төслийг төсвийн тусгай шаардлагын хамрах хүрээнээс хассан нь шинэ сорилт үүсгэх бөгөөд тайлагналыг олон улсын сайн туршлагад нийцүүлэх арга хэмжээ авах шаардлагатай. Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай шинэчлэлд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд оруулдаг тооцооллыг илүү нарийвчилсан, бодитой болгох замаар бэхжүүлэх, уул уурхайн орлого төвлөрдөг сангуудын засаглалыг сайжруулах, Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг сэргээх зэрэг арга хэмжээ хамаарна. Мөн төсвийн эрсдэлийг хянах, багасгах стратеги шаардлагатай бөгөөд энэ нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн засаглал, хяналтыг сайжруулах, төр, хувийн хэвшлийн түншлэлээс үүсэж болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг багасгах, орон нутгийн байгууллагуудтай уялдаа холбоог сайжруулах, Монгол Улсын Хөгжлийн банкны тайлан тэнцэл болон засаглалтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд чиглэх ёстой.

Мөнгөний бодлогыг хатуу хэвээр хадгалах шаардлагатай. Одоогийн хүнс, шатахууны үнийн шок нь инфляцын хүлээлтийг тогтворгүй болгож, хоёр дахь үеийн нөлөө үүсэх эрсдэлийг нэмэгдүүлбэл Монголбанк мөнгөний бодлогыг нэмж хатууруулахад бэлэн байх хэрэгтэй. Монголбанк гадаад валют болон ханшийн

эрсдэлээс хамгаалах хэрэгслийн гол нийлүүлэгчийн үүргээсээ үе шаттайгаар татгалзаж, валютын ханшийн уян хатан байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ нөхцөл бүрдсэн үед гадаад валютын улсын нөөцийг хуримтлуулах нь эдийн засгийн гадаад шокийг шингээх чадварыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Монголбанкны бодлого, үйл ажиллагаанд итгэх итгэл, үр нөлөөг бэхжүүлэх шинэчлэлийг эрчимжүүлэх шаардлагатай. Нэн тэргүүнд Монголбанкийг төсвийн шинжтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг зогсоож, ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх ажил удааширч байгааг эрчимжүүлж, холбогдох татаасыг төсөвт ил тод тусгах шаардлагатай. Монголбанкны зорилт, бие даасан байдал, засаглал болон өөрийн хөрөнгийн байдлыг сайжруулах зорилготой Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг эцэслэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй. Түүнчлэн орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банк байгуулах асуудлыг сайтар нягталж, олон улсын сайн туршлагыг баримтлахыг зөвлөж байна.

Макро зохистой бодлогын тогтолцоог нэмж сайжруулах шаардлагатай. Монголбанк Санхүүгийн тогтвортой байдал болон макро зохистой бодлогын асуудлыг тусгайлан хэлэлцэх Мөнгөний бодлогын хорооны хурлыг зохион байгуулж байхаар шийдвэрлэсэн, мөн Санхүүгийн тогтвортой байдлын газрыг шинээр байгуулсан нь сайшаалтай алхам боллоо. Цаашид Монголбанк макро зохистой бодлогын арга хэрэгслийн сонголтыг өргөжүүлэх, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран бодлого, үйл ажиллагааны уялдаа холбоогоо сайжруулах зэрэг арга хэмжээг нэмж авах шаардлагатай байна. Мөн эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг үргэлжлүүлэн сайжруулахын зэрэгцээ зээлийн мэдээлэл, төлбөрийн чадваргүйдэл болон банкны бүтцийн өөрчлөлтийн эрх зүйн орчинг шинэчлэх нь санхүүгийн салбарын эрсдэл даах чадварыг бэхжүүлэхэд чухал байна.

Тогтвортой, хүртээмжтэй өсөлтөд хүрэхэд бүтцийн шинэчлэлүүд чухал хэвээр байна. Хөрөнгө оруулалтыг дэмжиж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахын тулд бизнесийн орчныг сайжруулах, засаглал, авлигатай тэмцэх тогтолцоо болон хууль дээдлэх зарчмыг бэхжүүлэх, мөн эдийн засгийн өсөлтийг илүү төрөлжсөн, хувийн хэвшилд тулгуурласан загварт шилжүүлэх нь тэргүүлэх чиглэл болж байна. Эдгээр зорилттой уялдуулан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль, Төрийн өмчит компанийн тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, мөн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл зэрэг хууль эрх зүйн гол шинэчлэлүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.

ОУВС-ийн ажлын хэсгийг найрсгаар хүлээн авч, илэн далангүй, бүтээлч яриа хэлэлцээ өрнүүлсэн Монгол Улсын эрх баригчид болон төр, хувийн хэвшлийн өргөн хүрээний төлөөлөлд ажлын хэсэг чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

Суурь тэнцэл (ОУВС-ийн тодорхойлолтоор)	4.3	2.7	3.2	-0.7	-2.8	-3.3	-3.2	-3.2	-3.3
Нийт орлого, тусламж	34.6	38.9	36.3	31.9	30.4	29.0	28.8	28.9	28.9
Суурь зарлага ба цэвэр зээл	30.3	36.2	33.1	32.5	33.2	32.4	32.0	32.2	32.2
Хүүгийн зардал	1.6	1.5	1.7	1.9	2.2	2.3	2.6	2.9	3.2
Нийт тэнцэл (ОУВС-ийн тодорхойлолтоор)	2.7	1.3	1.5	-2.6	-5.0	-5.7	-5.8	-6.1	-6.5
Уул уурхайн бус суурь тэнцэл (ДНБ-д эзлэх хувиар)	-5.7	-8.8	-5.6	-8.5	-10.4	-10.5	-10.1	-9.9	-9.7
Санхүүжилтийн нийт хэрэгцээ	9.0	4.7	3.0	5.5	9.1	11.9	12.3	14.1	17.4
Засгийн газрын өр 1/	46.7	44.1	45.1	47.3	50.6	54.2	57.4	59.6	62.0
Дотоод	3.3	3.1	3.2	4.7	5.5	6.8	8.7	10.0	11.2
Гадаад	43.4	41.0	41.9	42.7	45.2	47.4	48.7	49.6	50.8
Мөнгө зээл									
Нийт мөнгөний өсөлт (өөрчлөлт хувиар)	24.2	15.5	10.6	20.3	17.5	14.0	12.8	12.4	12.1
Нөөц мөнгөний өсөлт (өөрчлөлт хувиар)	7.4	51.9	39.5	20.3	17.5	14.0	12.8	12.4	12.1
Зээлийн өсөлт (өөрчлөлт хувиар)	22.0	30.3	19.8	17.0	16.4	15.0	13.8	13.1	12.8
Төлбөрийн тэнцэл									
Урсгал дансны тэнцэл	0.6	-10.4	-8.4	-4.7	-4.9	-5.5	-6.2	-7.3	-7.7
Барааны экспорт	68.5	62.0	60.5	67.3	65.3	61.8	58.9	56.7	54.8
Барааны импорт	46.1	49.0	44.7	46.8	45.1	43.6	42.4	42.4	41.9
Гадаад валютын нийт албан нөөц (GIR, сая ам. доллар)	4,922	5,510	7,005	7,283	7,286	7,268	7,248	7,276	7,273
(импортын сараар)	3.6	4.1	4.4	4.3	4.2	4.0	3.8	3.6	3.5
(банкуудын МБ дахь валютын харилцахыг хассан)	3,491	4,233	5,739	...	...	...	...	...	...
Гадаад валютын цэвэр албан нөөц (NIR, сая ам. доллар) 2/	1,152	1,768	3,326	...	...	...	...	...	...
Валютын ханш									
Төгрөг/ам. доллар (хугацааны эцэст)	3,411	3,420	3,557	...	...	...	...	...	...

Эх сурвалж: Монгол Улсын төрийн эрх бүхий байгууллагууд; ОУВС-ийн мэргэжилтнүүдийн төсөөлөл.

1/ Хөгжлийн банкны нийт өр, Засгийн газраас ТӨК-д ил тод олгосон баталгаа, Эрдэнэт үйлдвэрийн хувьцаатай холбоотойгоор Засгийн газрын ХХБ-тай хийх төлбөр тооцооны хүрээнд МБ-ны өмнө хүлээсэн өр төлбөрийг оруулсан. МБ-ны Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлцлийн ашигласан дүнг оруулаагүй.

2/ NIR гэдгийг GIR-аас арилжааны банкууд, Засгийн газрын МБ дахь ам. долларын харилцахын үлдэгдэл, Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлцлийн ашигласан дүн, ОУВС-д төлөх өрийг хассанаар тооцсон.